

Хөдөө Аж Ахуй Хөдөө Орон Нутгийн Хөгжлийг Дэмжих Төсөл

2007 оны 5 дугаар сард зарлагдсан төсөлд хамрагдах тухай 2 дахь удаагийн зарын дагуу өргөдөл өгсөн компаниудыг үнэлэх үе шатууд.

2007 оны 5 дугаар сарын 31нээс өмнө буюу өргөдлийн маягт хүлээн авах эцсийн өдөр хүртэл шинээр 13 компани төсөлд хамрагдах өргөдөл ирүүлсэн байна. Компаниудын нэрсийг **А** жагсаалт (Хавсралт)-аас үзнэ үү.

2007 оны 5 дугаар сард зарлагдсан зарын дагуу 2 дахь ээлжинд өргөдөл өгсөн компаниудыг шударгаар үнэлэхийн тулд тэдгээр шинэ компаниудыг үнэлэх үнэлгээний систем, оноо өгөх, байр эзлүүлэх журмыг 2007 оны 1 дүгээр сард эхний ээлжинд өргөдөл өгсөн компаниудынхтай яг адил байлгах зарчмыг 2007 оны 5 сарын 25ны өдрийн төслийн Зөвлөлийн хурлаар санал нэгтэй зөвшөөрсөн болно.

Дараахь үе шатуудаар үнэлгээ хийнэ.

1 дүгээр үе шат – Өргөдлийн маягтыг үнэлэх анхны үнэлгээ

- Шинээр өргөдөл өгсөн /**А** жагсаалтад хавсаргасан нийт 13 компани/ компаниуд өргөдлийн маягтад заасан мэдээллийг бүрэн гүйцэд ирүүлсэн эсэхийг хянах. Бүрэн гүйцэд бус өргөдөл ирүүлсэн компаниудыг хасна.
- Үлдсэн компаниудын өргөдөлд Төслийн зөвлөлийн хурлаар хэлэлцэн баталсан үндсэн болон нэмэлт шалгуурын дагуу үнэлгээ хийнэ. Үндсэн шалгууруудаас хоёрыг нь хангаагүй буюу Зөвлөлийн хурлаар хассан /гурилын үйлдвэр гм/ салбарт үйл ажиллагаа эрхэлж буй бол шалгаруулалтаас хасагдана.
- Дээрхи хоёр шалгаруулалтын үр дүнгээс хамаарч шинээр **В** жагсаалт гаргана. Энэхүү жагсаалтад өргөдөлд ирүүлсэн мэдээлэлд үндэслэн гадаад болон дотоод зах зээлд niche, өртөг нэмэгдсэн бүтээгдэхүүнийг хөгжүүлэх нөөц боломжтой байх гэсэн сүлжээний толгой компанид төслөөс тавигдах шаардлагыг хангаж буй гэж үзсэн компаниудыг багтаана.
- **В** жагсаалтад багтсан компаниудын өргөдлийн маягтуудыг өмнө нь төслийн зөвлөлийн хурлаар батлагдсан оноо өгөх системийн дагуу үнэлнэ.

2 дугаар үе шат – Шинээр өргөдөл өгсөн компаниудыг өмнө нь өргөдөл өгсөн компаниудтай харьцуулан үнэлэх

- Эхний ээлжинд өргөдөл ирүүлсэн компаниудаас 65 компани шалгарч үлдсэн бөгөөд тэдний өргөдлийг үнэлж оноо өгсөн болно. Энэ компаниудыг багтаасан **С** жагсаалтыг гаргаж төслийн зөвлөлд 2007 оны 2 дугаар сарын 9-ний өдөр танилцуулав.
- Шинээр орж буй компаниудыг шударгаар, эхний ээлжинд өргөдөл өгсөн компаниудтай яг ижил үнэлгээгээр үнэлэх зорилгоор **С** жагсаалтаас дараахь компаниудыг хасах замаар шинээр **Д** жагсаалт гаргана:
 - 1) Төслийн зөвлөл хэлэлцээд цаашид хамтран ажиллах, үйл ажиллагаанд нь газар дээр нь бодитой үнэлгээ хийхэд тохиромжтой гэж үзсэн 33 компани.
 - 2) Төслийн зөвлөлийн хурлаар хэлэлцээд толгой компани байх статусгүй гэдэг үндэслэлээр хасагдсан /гурилын үйлдвэр гм/ компаниуд.

- Иймд **D** жагсаалтад эхний ээлжинд өргөдөл ирүүлсэн 65 компаниас Төслийн зөвлөлөөс сонгон шалгаруулсан 33 компани, гурилын үйлдвэрлэл эрхэлдэг 4 компанийг хасч тооцон нийт 28 компани багтаж байна.

3 дугаар үе шат – Компаниудыг байр эзлүүлэх

- **B** болон **D** жагсаалтад буй компаниудын нэрсийг нийлүүлэн шинээр **E** жагсаалт гаргах бөгөөд энэ жагсаалтад дээр дурьдсан 28 компани дээр 13 хүртэлх тооны компанийг шинээр нэмж нийтдээ 41 хүртэлх тооны компанийг багтаана.
- **E** жагсаалтад багтсан компаниудыг Төслийн зөвлөлийн хурлаар батлагдсан онооны системийн дагуу онооны дарааллаар жагсаана.

4 дүгээр үе шат – Бодит үнэлгээ

- **E** жагсаалтад багтсан эхний 10 компанийн өргөдлийн маягтад өгсөн мэдээллийн үнэн зөв, бүрэн гүйцэд байдлыг туршлагатай үндэсний зөвлөх газар дээр нь очиж бодит байдалтай нь харьцуулан үнэлгээ хийнэ.
- Бодит байдлыг газар дээр нь очиж шалгасны дараа хэрэв шаардлагатай бол бодит байдалд нийцүүлэх үүднээс урьд нь өгсөн оноог өөрчилж болох бөгөөд ийнхүү оноог шинэчилсний дараа дахин байр эзлүүлж шинээр **F** жагсаалт гаргана.
- **F** жагсаалтыг Төслийн зөвлөлд танилцуулснаар зөвлөл компаниудын талаар хэлэлцэж сонголтоо хийнэ.

5 дугаар үе шат – Компаниудыг сонгон шалгаруулах

- Төслийн зөвлөл **F** жагсаалтад багтсан компаниудаас сонгон шалгаруулж өмнө нь сонгон шалгаруулсан 21 компани дээр нэмнэ.
- Өмнө нь сонгон шалгаруулсан 21 компани дээр нэмж Зөвлөлийн хурлаар шинээр шалгаруулсан компаниудыг төслийн санал бичихэд нь туслалцаа үзүүлэх зорилгоор туршлагатай үндэсний зөвлөхөөр хангана.

Жагсаалт А

2007 оны 5 дугаар сард гаргасан зарын дагуу төсөлд хамрагдахаар
өргөдлөө ирүүлсэн компаниуд

№	Компаний нэр	Харилцах хүний нэр	Үйл ажиллагааны гол салбар	Өргөдөл өгсөн эсэх
1	Жаст групп (мах маркет)	Ганчимэг	Мах	Тийм
2	Мах импекс	Бүдрагчаа	Мах	Тийм
3	Би Эс Монгол	Дэлэг	Мах	Тийм
4	Хөвсгөл Алтандуулга	Батхуяг	Мах	Тийм
5	Дорнын говь	Цогтбаатар	Мах	Тийм
6	Камо мийт	Шадав	Мах	Тийм
7	Монсүү	Болдмаа	Сүү боловсруулах	Тийм
8	Сүү	Баярдалай	Сүүн бүтээгдэхүүн	Тийм
9	Модерн кастл модифайрс	Алтанчимэг	Барилга, ногооны зорь	Тийм
10	Энтоуз	Сэлэнгэ	Улаан буудай, гурил, гурилын үйлдвэр	Тийм
11	Миний дэлгүүр супермаркетууд	Алтантүлхүүр	Төмс, мах гм бүтээгдэхүүний худалдаа	Тийм
12	Алтандуулга	Одгэрэл	Үр тариа, улаан буудай	Тийм
13	Увс гурил	Тунгалаг	Улаан буудай тариалах, гурилын үйлдвэр	Тийм